

ЭД ХӨРӨНГИЙН БҮРЭН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

20... оны ...-р сарын...ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “.....” ХХК /цаашид “компани ” гэх /, түүнийг төлөөлж, захирал, нөгөө талаас “.....”ХХК-..... ажил, албан тушаалтайнар/цаашид“ажилтан” гэх /компаний мөнгө, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн “3,4”, 136 дугаар зүйлд заасныг үндэслэн дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 1.1. Ажилтан нь дор дурьдсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.
 - 1.1.1. Ажилтан нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас хариуцсан мөнгө, үнэт зүйл, эд хөрөнгийг дутагдуулсан, шамшигдуулсан, бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан зэргээр компанид хохирол учруулбал сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг нөхөн төлнө.
 - 1.1.2. Ажилтны хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг болохыг тогтоосон шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон
 - 1.1.3. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан ажилтан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид тухайлан заасан
 - 1.1.4. Тайлан дараа гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан мөнгө, эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийн тооцоог хийгээгүй, зөрүүг эргүүлж төлөөгүй
 - 1.1.5. Эрхэлсэн ажилтай нь холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар олгосон ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн
 - 1.1.6. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ компанид хохирол учруулсан
- 1.2. Бэлэн мөнгийг орлогод авах, зарлага гаргахдаа кассын өдөр тутмын үндсэн баримтыг иш үндэслэл болгож тооцоог тогтмол хугацаанд, шаардлагатай үед, гэнэтийн гэсэн хэлбэрээр хийнэ.
- 1.3. Энэхүү гэрээ нь эд хариуцсан ажилтанд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх нэмэлт гэрээ бөгөөд хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг мөн.
- 1.4. Гэрээний хугацаа нь хөдөлмөрийн гэрээний ерөнхий хугацаатай адил байхаар зохицуулагдана.

ХОЁР. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Захиргаа эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болох ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ байгуулах үүрэгтэй.
- 2.2. Захиргаа нь ажилтанд мөнгө, эд хөрөнгийг хариуцуулан өгч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас компанид хохирол учруулбал хохирлыг төлүүлэн авах эрхтэй.
- 2.3. Захиргаа нь ажилтанд хариуцуулсан мөнгө, үнэт зүйл, эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгахыг шаардах, шалгах, тооллого хийх, зөрчил илэрсэн бол акт тогтоох, ажилтнаас бичгээр тайлбар авах, бусад холбогдох баримтыг бүрдүүлэх эрхтэй.
- 2.4. Компаниас ажилтанд албан үүргээ гүйцэтгэхэд нь зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг баримтаар хүлээлгэн өгч, түүнийг хэвийн байдлаар ашиглах, хамгаалахын тулд шаардлага хангасан ажиллах орчноор хангах, ажлын техник тоног төхөөрөмж болон цоож, лац, ломбоор хангана.
- 2.5. ... /Үргэлжлэл бий /